

Тавантолгой ХК

Хувьцаа эзэмшигчийн 2012 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн хурлаар батлан хэлтэс

TTC2514 34/1-14

**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ДҮРЭМ**
Нэг. Нийтлэг үндэслэл.

3
Хэлтэсийн өдрийн улсын бүртгэлийн
дугаар ... 1110001005 ...
2012 оны 06 сарын 20 -ны өдөр
Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэгчийн
гарын үсэг ... М. Энхтамгаа...

- Энэхүү дүрэм нь тус компанийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчид, ажилчид, хэрэглэгч дотоод, гадаадын байгууллагуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- “Таван толгой” хувьцаат компани нь /цаашид компани гэх/ Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн үүсгэн байгуулагдсан, орон нутгийн өмч давамгайлсан хувьцаат компани мөн.
- Компанийн оноосон нэр “Тавантолгой” ХК. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулна.
- Хаяг: Өмнөговь аймгийн Цогтцэций сум: “Тавантолгой” ХК
- Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийг мөрднө.

Хоёр. Эрх хэмжээ

- “Тавантолгой” ХК нь өөрийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаанд оролцож, энэхүү дүрэмд заасан болон хуулиар эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.
- Компани нь ашигт ажиллагааны зорилтот түвшин, олон үет болон ойрын хугацааны бизнес төлөвлөгөөг салбарын яам, мэргэжлийн байгууллагаар хянуулж, хувьцаа эзэмшигчийн хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, удирдлага болгон ажиллана.
- Компани нь яам тусгай газар, мэргэжлийн байгууллага, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан тогтоол, хувьцаа эзэмшигчийн хурал, ТУЗ, шийдвэрийг удирдлага болгон ажиллана.
- Үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардагдах түүхий эд материалыа бие даан бэлтгэж, үйлдвэрлэсэн, олборлосон, бүтээгдэхүүнийхээ борлуулалтыг хариуцана.
- Өөрийн эзэмшилд байгаа өмчийг эзэмших, захирэн зарцуулахдаа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрднө.
- Компани нь өөрийн тэмдэг, билэгдэл, бичгийн хэвлэмэл хүрээтэй байна.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл

- “Тавантолгой” ХК нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх доорхи үйл ажиллагааг явуулна. Үүнд:
А. Үндсэн үйлдвэрлэл:
- Нүүрс олборлолт, борлуулалт

Тавантолгой ХК

Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн хурлаар батлав.

4

- Кокс үйлдвэрлэлт, борлуулалт

Б. Туслах үйлдвэрлэл:

- Гадаад, дотоод худалдаа
- Мал аж ахуй эрхлэх
- Газар тариалан эрхлэх
- Ачаа тээвэр
- Гуанз
- Зочид буудал
- Халуун ус
- Дэлгүүр
- Холбоо
- Эрчим хүч үйлдвэрлэх
- Дулаан хангамж
- Үндны усан хангамж

В. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Дөрөв. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө

34/1-14

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 52,665,200 төгрөг байна. Үүнээс 51% нь нутгийн өмч бөгөөд 49% нь хувьцаа эзэмшигчдийн өмч байна.
2. Компани нь нэг бүр нь 1 төгрөгийн үнэтэй 52,665,200 ширхэг энгийн хувьцаа гаргаснаас 51 % буюу 26,859,300 ширхэг нь орон нутгийн мэдлийн өмч байна. Хувьцаа бүр саналын 1 эрхтэй байна.
3. Компанийн үйл ажиллагаанаас буй болсон хөрөнгө нь дээрх харьцаагаар эзэмшигдэх болно.
4. Дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Компанийн дүрмийн санг нэмэгдүүлсэн тохиолдолд шинээр хувьцаа гаргах, түүний төрөл, хэлбэр, нэрлэсэн үнэ, тоог тогтоох, худалдах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өгсөн зөвшөөрлийн дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. Дүрмийн сангийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.
5. Энгийн болон давуу эрхийн хувьцаа нэмж гаргах, гаргасан хувьцаагаа эргүүлэн авах, эсвэл бусад төрлийн үнэт цаас, эд хөрөнгөд хөрвүүлэх шийдвэр Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.


Тав. Хувьцаа эзэмшигчдийн эрх

1. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх. Компанийн тухай хуулийн 46-р зүйлд заасны дагуу ногдол ашиг авах.

2. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
3. Энгийн хувьцаа эзэмшигчид нь компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
4. Компани нь давуу эрхийн хувьцааг гаргавал Компанийн тухай хуулийн 34,36 дугаар зүйлүүдийн дагуу эрх олгогдоно.
5. Хувьцаа эзэмшигчид нь Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох, түүний гаргасан шийдвэр баримт бичигтэй танилцах эрхтэй.
6. Хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцааг бусад шилжүүлэх эрхтэй.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн хурал

1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байна.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хүгэцаанд ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
4. Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санал, шаардлага гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлд заасан журмын дагуу зарлан хуралдуулна. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах зардлыг компани гаргана.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг хурал зарласан этгээд хурал хуралдуулах шийдвэрт заана. Хэрэв хурал өөр хүн сонгоогүй бол хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдана.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг ТУЗ, эсхүл компанийн тухай хуулийн 61.7 -д заасан этгээд гаргана.
7. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:
 - 7.1. Хурал хуралдуулах газар, өдөр болон цаг;
 - 7.2. Хурлын хэлэлцэх асуудал;
 - 7.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 7.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдийн мэдэгдэх өдөр, журам;
 - 7.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт;
 - 7.6. Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;

- 7.7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
- 7.8. Хурлын дарга;
- 7.9. Тооллогын комиссын дарга, гишүүд;
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэх ба уг хурлыг хүчин төгөлдөр гэж тооцно.
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргаар санал хурааж шийднэ.
10. Энэ дүрмийн 14.1-14.7 –д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
11. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид, мөн тэдний итгэмжлэгчийг хурлыг зарласан өдрөөс хурал хуралдах өдөр, цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга бүртгэнэ. Нарийн бичгийн даргын эзгүйд Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсойн хүн бүртгэнэ.
12. Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцбх этгээд энэ тухай Төлөөлөн удирдах зөвлөлд хурал хэлхээс өмнө мэдэгдэнэ 
13. Төлөөлөх тухай итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй. Харин хурал хойшлогдож, хэлэлцэх асуудал өөрчлөгдөөгүй бол итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй.
14. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 14.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - 14.2. Компанийг нийлэх, нэгтгэх, хуваах зэргээр өөрчлөн байгуулах;
 - 14.3. Компанийн өрийг хувьцаагаар солих;
 - 14.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 14.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комисс томилох;
 - 14.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 14.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлгчдээс бусад гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 14.8. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх;
 - 14.9. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 14.10. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах, 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 14.11. Компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх;
 - 14.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хэмжээг тогтоох;

- 14.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 14.14. Компанийн эзэмшиж байгаа ашигт малтмалын орд газрын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл, эзэмшлийн бүх газар зөвхөн компанийн нэр дээр байна.
15. Хурлын зар мэдэг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ. Зар мэдээнд тусгах зүйлийг Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооноос тусгайлан баталсан журмын дагуу тусгана.
16. Хурал хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилно.
17. Хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн албан тушаалтан болон эдгээр хүмүүстэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр оруулахыг хориглоно.
18. Хурлын тооллогын комисс нь Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн дагуу ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнтгийн үнэн зөвийг хариуцна.
19. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, тэмдэглэлд хурлын дарга гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

Долоо. Төлөөлөн удирдах зөвлөл

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. Орон нутгийн 51% өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас томилох ба тэд 49%-ийн төлөөллийн төлөө саналаа өгөхгүй.
- ТҮЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна:
 - Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшидэггүй.
 - Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанийд эрх бүхий албан тушаал хашдаггүй
 - Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй
- Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

- 8
- 4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын зорилт тутамд эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 4.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон хувьцааны төрөл гарах;
 - 4.5. Үнэт цаас гарах;
 - 4.6. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдааны буюу эргүүзэн авах;
 - 4.7. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний буюу эргүүзэн тогтоох;
 - 4.8. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах тэрээний нэхмийн тогтоох; олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 4.9. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх тэрээний нөхцлийг тогтоох;
 - 4.10. Компанийн уйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талын дүгнэлтийн гарах;
 - 4.11. Компанийн ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төслийн журмыг тодорхойлох;
 - 4.12. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл зорилтуудын журмыг батлах;
 - 4.13. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
 - 4.14. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 4.15. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 4.16. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 4.17. Бусад асуудал.
 - 4.18. Зах зээлийн үнэ тогтоох, аудиторыг сонгох, сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх хүнийг томилохдоо Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд оролцож саналаа өгнө.
 - 5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг компанийн тухай хуулийн 77.1-д засаны дагуу сонгогдоно.
 - 6. ТҮЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТҮЗ-ийн Нэр дэвшигчдийн хороо түр томилно. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавих энэ дүрмийн 7.3-т заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэх ёстой.
 - 7. ТҮЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТҮЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.
 - 8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл
шиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах,
хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

ТҮЗ-ийн даргын эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын
комилсон аль нэг гишүүн удирдана.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард 1 удаа хуралдуулна. Шаардлагатай гэж
үзэл нэмэлт хуралдаан хийж болно. ТҮЗ-ийн шийдвэр нь тогтоол байна.
Тогтоолд дарга гарын үсэг зурсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх
шилдлага, хувьцаа эзэмшигчийн үндэслэл бүхий шаардлага, санаачилгаар
хуралдуулна. Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж
болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор
хүчин төгөлдөр болж шийдвэрийг оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн
саналаар шийдвэрлэнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр саналтын нэг эрхтэй байх ба санал
хиссэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана. Үүнд:

- 15.1. Хурал хийсэн цаг, өдөр, газар;
- 15.2. Хуралд оролцсон гишүүд;
- 15.3. Хурлаар хэлэлцэгдсэн асуудлууд;
- 15.4. Санал хураалтаар шийдвэрлэсэн бол санал хураалтын дүн;
- 15.5. Гаргасан шийдвэр;

Хурлын тэмдэглэлд хурлын дарга, хуралд оролцсон ТҮЗ-ийн гишүүд, нарийн
бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын
дарга хариуцна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн явдал тус
хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн
даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

- 19.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг
хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх;
- 19.2. Хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл
болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу
бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;
- 19.3. Хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
тэмдэглэлийн хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу
багалгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

- 19.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;
- 19.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах.

Найм. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

1. Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
2. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээрр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
3. ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.
- 3.1. компанийн НББ-ийн бодлого болон НББ нь ОУНББ-ийн болон үндэсний стандартад нийцсэн байдал, дотоод хяналтын болон эрэдэлийн удирдлагын үйл ажиллагаанд болон бүртгэл, бусад тайлангийн мэдээллийг үнэн бодит байдалд хяналт тавих,
- 3.2. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих
- 3.3. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах
- 3.4. хөндлөнгийн аудитийн байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитийн байгууллагад чиглэл өгөх, /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитийн байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/
- 3.5. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих,
- 3.6. ТУЗ-өөс үүрэг болгосон бусад асуудал
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй.
- 4.1. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох
- 4.2. ТУЗ-ийн болон үйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд энэ дүрмийн 7.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах

Тавантолгой ХХК

Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн хурлаар батлав.

- 4.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшиүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/
- 4.4. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх
- 4.5. гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;
- 4.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй.
 - 5.1. эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 5.2. эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал бооловсруулах
 - 5.3. компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.
6. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргааас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах
 - 6.2. компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах
 - 6.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шидвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах
7. Орон нутгийн өмч давамгайлсан /50-аас дээш хувийн оролцоотой/ компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн энэ дүрмийн 8.6-д зааснаас гадна дараах нэмэлт эрх үүрэгтэй байна:
 - 7.1. төрийн болон орон нутийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа ажил үйлчилгээг худалдан авч талаар санал боловсруулах
 - 7.2. Бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг дээр хуулиар тогтоосон зарчим, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн боловсруулсан саналын дагуу худалдан авч байгаа эсэхэд хяналт тавих

Ес. Гүйцэтгэх удирдлага

1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
2. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ.
3. Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байж болохгүй.
4. Орон нутгийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болохгүй.
5. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд тусгасан нөхцлүүдийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн тогтоож, гэрээнд гарын үсгийг ТУЗ-ийн дарга зурна.
6. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэрэгээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. 34/1-14
7. Компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Арав. Компанийн эрх бүхий албан тушаалтны хариуцлага

1. ТУЗ, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий менежер, эдийн засагч, маркшайдер, технологи инженер, механик инженер зэрэг албан тушаалтыг компанийн эрх бүхий албан тушаалтан гэнэ.
2. Компанийн эрх бүхий албан тушаатнууд нь компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж компанийн ашиг сонирхлын төлөө үзүүч шударгаар ажиллана. ТУЗ-ээс зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг гуравдагч этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэмжээг тогтоох, асуудлыг ТУЗ-тэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүх шийдвэрлэнэ.
4. Компанийн эрх бүхий албан тушаалтан санаатайгаар дараах хууль бус үйл ажиллагаа явуулсан бол компани болон түүний хувьцаа эзэмшигчдэд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна. Үүнд:
 - Хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан;
 - Компанийн хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгч болон бусад харилцагчид хуурамч мэдээлэл өгсөн;

Тавантолгой ХХК

Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн хурлаар батлав.

- Компанийн түүхийн 99 дугаар зүйлд заасан шаардлага зөрчиж нэгдмэл сонирхолтой этгээд болохоо мэдэгдээгүй;
 - Мөн хуулийн 97 дугаар зүйлд заасан журмын дагуу бичиг баримтыг хадгалаагүй;
 - Энэ дүрмийн 10.2-т заасан зарчмыг баримтлаагүй;
 - Ногдол ашиг хуваарилах, хувьцаа худалдан авах нөхцөлийг мөрдөөгүй, ТУЗ-тэй байгуулсан гэрээ, компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн.
5. Дээрх хариуцлагыг бусад хуульд заасан хариуцлагатай давхар хүлээлгэж болно.
 6. Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанийд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжилэл гаргах эрхтэй.

Арван нэг. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, мэдээлэл

1. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигчийн болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
 2. Компанийн санхүүгийн жил 01 дүгээр сарын 01-нээс эхэлж 12 дугаар сарын 31-нд дуусна.
 3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захидал хариуцна.
 4. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигч нарт зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан илтгэл бичиж тайлагнана.
 5. ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргахын өмнө санхүүгийн тайланг аудитор шалгаж баталгаажуулна.
 6. Компани нь өөрийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, нэдмэл сонирхолтой этгээдийн нэрс, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл болон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулна.
 7. Компани нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр, гүйцэтгэх захирлын тушаал болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад бичиг баримттай танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчдэл олгоно.
 8. Компани нь дараах бичиг баримтыг хадгална. Үүнд:
- Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт;
 - Компанийн үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, бүртгэлийн гэрчилгээ;
 - Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захиралаас баталсан дотоод бичиг баримт;
 - Салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм;
 - Ня-бо бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт;
 - Бүх төрлийн хурлын тэмдэглэл, шийдвэрүүд;
 - Аудиторын дүгнэлт;

Тавантолгой ХК

Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын
30-ны өдрийн хурлаар батлав.

- Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
- Аянхан шатны болон ня-бо бүртгэлийн бүртгэлийн бичиг баримт;
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;
- 9. Компанийн бичиг баримтыг хөтлөх, хадгалах журмын дагуу архивт өгөх үүргийг нарийн бичгийн дарга хүлээж, ТУЗ-ийн дарга хяналт тавина.

Арван хоёр. Ногдол ашиг хуваарилалт

1. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн байна. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ. *БУРГҮҮЛСҮН*
2. Компанийн жилийн санхүүгийн тайлангарсны дараа дор дурдсан нөхцөлд татвар төлсөний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
 - 2.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
3. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчидээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
4. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувь нийлүүлэгчдийн хуралд тайлагнана.

Арван гурав. Бусад асуудал

1. Компанийн онцлогтой холбоотой энэ дүрмэнд заагдаагүй бусад харилцааг компанийн тухай хуулийг үндэслэн зохицуулна.
2. Дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тухай асуудлыг ТУЗ боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна.